Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, МАГАДЛАН ИТГЭМЖЛЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН АДЬЯАДОРЖИЙН ДОЛГОРХАНДЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилт 1. Хүн амын эрэлт хэрэгцээг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг боловсронгуй болгох | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1. Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна. | Тэргүүлэх чиглэл баталсан эрүүл мэндийн сайдын тушаал | - | Тэргүүлэх чиглэл шинэчлэгдэн батлагдсан байна. | Монгол Улсын хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан 2024-2027 онд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хязгаарлах, олгохгүй чиглэлийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, Эрүүл мэндийн яамны газрын дарга нараар тойруулж зуруулан батлуулахад бэлэн болсон. | 2024.01.01-2024.12.31 | 90% |
| 2. | Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. | Эрүүл мэндийн сайдын тушаал | - | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна. | - Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлж байгаатай холбоотой “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар | 2024.01.01-2024.12.31 | 90% |



55

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл аваад мөрдөх шалгуур үзүүлэлтийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2/3928 дугаар албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт шилжүүлэв.<br>- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх ажлын байранд үнэлгээ хийх хяналтын хуудас (нийтлэг шаардлага болон өвөрмөц шаардлагаар), ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудас, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, батлуулахад бэлэн болсон. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн tzmoh.gov.mn цахим програмыг тусгай зөвшөөрлийн цахим систем буюу license.mn-д холбох, хөгжүүлэлт хийнэ. | Програмын холболт, хөгжүүлэлт | - | | - Монгол Улсад Зөвшөөрлийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой Зөвшөөрлийн цахим систем (License.mn)-ээр дамжуулан эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож эхлээд байна. Эхний ээлжинд Эрүүл мэндийн яаманд ирүүлж буй эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүсэлтийг 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Зөвшөөрлийн цахим систем (License.mn)-ээр хүлээн авч байна.<br>- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газар, Нийслэлийн эрүүл мэндийн газар, Өмнөговь, Орхон аймгийн Эрүүл мэндийн газраас олгож буй тусгай | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зөвшөөрлийг "туршилтын орчин"-д Зөвшөөрлийн цахим систем (License.mn)-ээр хүлээн авч эхлээд байна.<br>- Одоогийн байдлаар Зөвшөөрлийн цахим систем (license.mn)-д улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 4,462 тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын мэдээллийг оруулж, цахим гэрчилгээ олгож эхэлсэн.<br>- Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой "Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрөлтэй холбоотой тушаал, шийдвэр, судалгаа, шалгуур үзүүлэлт зэрэг холбогдох баримт бичгийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт Төрийн нарийн бичгийн даргын 2024.09.25-ны өдрийн 2/3928 дугаар албан бичгээр шилжүүлсэн. | | |
| | Арга хэмжээ 1.4 Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох хурлыг зохион байгуулах, Эрүүл мэндийн сайдын тушаал гаргана. | Тусгай зөвшөөрлийн хурлын шийдвэрийг тусгасан Сайдын тушаал | Хурлын шийдвэр бүрийг тусган гаргасан Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна. | - Тусгай зөвшөөрлийн хүсэлт илгээсэн аж ахуйн нэгж, байгууллагаас хүсэлтийн дагуу ажлын байрны шинжээч ажиллах 15 удаагийн удирдамжийг Тусгай зөвшөөрлийн комиссын даргаар батлуулж, ажиллалаа.<br>- Тусгай зөвшөөрлийн комиссын хурлыг 10 удаа төлөвлөгөөтэйгээр, 1 удаа яаралтай хэлбэрээр хуралдуулж, удирдамжийн дагуу шинээр тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргасан 20, сунгах хүсэлт болон хаяг нэршил өөрчлөх 64, тусгай зөвшөөрөл сэргээх хүсэлт илгээсэн 2, нэмэлт тодруулга хийх 3, гомдлын дагуу дахин үнэлгээ хийх 1 байгууллагад давхардсан тоогоор 197 шинжээчдийг багаар томилон ажиллуулсан.<br>- Шинжээчдээс ирүүлсэн 81 ажлын байрны дүгнэлтийг хянан хүлээн авч, Тусгай | 2024.01.01-2024.12.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | - зөвшөөрлийн комиссын хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.<br>- Тусгай зөвшөөрлийн комиссын хамтарсан хурлын шийдвэрээр 15 байгууллагад шинээр тусгай зөвшөөрөл олгосон бол 39 байгууллагын тусгай зөвшөөрлийг сунгаж, 24 байгууллагын тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлж, 13 байгууллагын тусгай зөвшөөрлийг сэргээж, 2 байгууллагын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Батлагдан гарсан эрүүл мэндийн сайдын тушаалыг ЭМЯ-ны цахим хуудсанд байршуулсан. | | |
| 5 | Арга хэмжээ 1.5 Тусгай зөвшөөрлийн шинжээчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана. | Сонгон шалгаруулалтын зар, мэдээлэл | Ажлын хэсгийн тушаал | Батлагдсан тушаал | - Тусгай зөвшөөрлийн шинжээч нарыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулан ЭМЯ, ЭМХТ-ийн цахим болон фейсбүүк хуудсанд байршуулж, сонгон шалгаруулалтыг зарласан. Зарын дагуу 56 эрүүл мэндийн ажилтан материалаа ирүүлсэн. 18 шинжээч 2 үе шатны шалгаруулалтаар тэнцсэн. | 2024.06.31-2024.08.30 | 100% |
| | Дэд арга хэмжээ 1.5.1 Тусгай зөвшөөрлийн шинжээч сонгон шалгаруулах ажлын хэсэг, удирдамж батлуулна. | Сонгон шалгаруулалтын удирдамж Ажлын хэсэг | | Батлагдсан тушаал | - Орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/74 дүгээр тушаалаар батлуулж, шинжээч нарын сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулсан. | 2024.06.31-2024.08.30 | |
| | Дэд арга хэмжээ 1.5.2. Тусгай зөвшөөрлийн шинжээчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад хууль журмын дагуу арга зүйн дэмжлэг үзүүлнэ. | Сонгон шалгаруулалтын тайлан | | Батлагдсан тушаал | - Орон тооны бус шинжээч нарыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/336-р тушаалаар томилж, 8 дугаар сарын 12-ны өдөр шинжээч нарт зориулсан сургалтыг Авлигатай тэмцэх газартай хамтран зохион байгуулж, хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. | 2024.06.31-2024.08.30 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Арга хэмжээ 1.6 "Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой төлбөрийн хэмжээ, зардлын жишиг батлах тухай" тушаалыг шинэчлэн батлуулна. | Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаал | Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/265, А/463-р тушаал | Батлагдсан тушаал | "Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн зардлын жишиг батлах тухай" Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалыг шинэчлэн боловсруулж, тушаалын төсөлд Эрүүл мэндийн сайдаар зуруулан 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 1а/4211 албан бичгээр Сангийн сайд Б.Жавхланд хүргүүлсэн. Сангийн яамнаас ирүүлсэн албан бичгийн хариунд нөлөөллийн үнэлгээ болон 2025 оны батлагдсан төсөвт тусгагдаагүй тул төслийг батлах боломжгүйг мэдэгдсэн байна.<br>Харин Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн төлбөрийн хэмжээ, зардлын жишгийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар шинэчлэн боловсруулж, магадлан итгэмжлэлийн гол тушаал болох Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503-р тушаал шинэчлэх үйл ажиллагаатай холбоотой түр хойшлуулсан. | 2024.06.01-2024.12.31 | 90% |
| Зорилт 2. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн судалгаа, төлөвлөлт, хэрэгжилтийг зохицуулах | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1 Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журмыг шинэчлэн батлуулна. | Магадлан итгэмжлэлийн журам баталсан эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503-р тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/503 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ын шинэчлэх ажлын хүрээнд магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор "Эрүүл мэндийн магадлан итгэмжлэлийн журам"-ыг боловсруулсан. Тушаалын төслийг шинжээч, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, лавлагаа шатлалын эмнэлгийн хүрээнд 3 удаа хэлэлцүүлгийг зохион байгуулж саналыг авсан.<br>Журмын төслийг 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Эрүүл Мэндийн Сайдад, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар танилцуулж, эрх зүйн орчинг дахин судалж боловсруулахаар буцаагдсан болно. | 2024.01.01-2024.11.20 | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 2.2 Эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. | Шалгуур үзүүлэлтийг баталсан эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554, 2020 оны А/179, А/180-р тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/303 дугаар тушаалаар батлагдсан Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн журмын шинэчлэлтэй холбоотой магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэхээр төлөвлөж ажилласан. Үүний хүрээнд:<br>- ЭМХТ-ийн Ерөнхий захирлын А/35 дугаар тушаалаар ажлын хэсгийг байгуулагдаж, ажлын хэсгийн уулзалтыг 3 удаа, арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан.<br>- Шалгуур үзүүлэлтийн дэд бүлгүүдийг шинжээчидтэй хамтран шүүлт хийж, эхний ээлжинд давхардсан утгатай шалгуур үзүүлэлтүүдийг хасах, нэгтгэх, өөрчлөх үйл ажиллагаа хийгдсэн.<br>- Олон улсын магадлан итгэмжлэлийн стандарттай харьцуулан шалгуур үзүүлэлтийн шинэчлэлийг хийх ажил үргэлжилж байна. | 2024.01.01-2024.12.31 | 30% |
| 3 | Арга хэмжээ 2.3 Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн хурлыг зохион байгуулна. | Магадлан итгэмжлэл олгосон байгууллагын жагсаалтыг баталсан Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаал | Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан байна. | Магадлан итгэмжлэлийн зөвлөлийн хурлыг 14 удаа зохион байгуулж, 321 эрүүл мэндийн байгууллагад магадлан итгэмжлэл олгож, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулан 17 байгууллагад магадлан итгэмжлэл олгоогүй байна.<br>Хурлын шийдвэр бүрийг баталгаажуулж, тэмдэглэл хөтлөн, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж, ЭМЯ-ны цахим хуудсанд байршуулсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 4 | Арга хэмжээ 2.4 Магадлан итгэмжлэлийн шинжээч нарын сонгон шалгаруулалтыг зохион байгуулна. | Сонгон шалгаруулалтын удирдамж | Ажлын хэсгийн тушаал | Удирдамж батлагдаж, сонгон шалгаруулалт явагдаж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар | Тусгай зөвшөөрлийн шинжээч нарыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлтийг боловсруулан ЭМЯ, ЭМХТ-ийн цахим болон фейсбүүк хуудсанд байршуулж, сонгон шалгаруулалтыг зарласан.<br>Орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамжийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/74 дүгээр тушаалаар батлуулж, | 2024.01.01-2024.06.31 | 100% |



90

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | албажсан байна. | шинжээч нарын сонгон шалгаруулалтыг 2 үе шаттай зохион байгуулж, 159 шинжээчийг хамруулсан.<br>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/336-р тушаалаар орон тооны бус шинжээчээр 63 эрүүл мэндийн ажилтныг томилж, баталгаажуулан, ЭМХТ-өөс хамтран ажиллах гэрээ байгуулж, сургалтад хамруулсан. | | |
| Зорилт 3. Тусгай зөвшөөрөлтэй, магадлан итгэмжлэгдсэн байгууллагуудын зөвшөөрлийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийх | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1<br>Гааль, Татвар, Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран тусгай зөвшөөрөл олгох байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулна. | Сургалтын хөтөлбөр, тайлан | Сургалт зохион байгуулагдсан байна. | Батлагдсан сургалтын хөтөлбөр<br><br>Сургалтын тайлан | Авлигатай тэмцэх газар, Гааль, санхүүгийн мэдээллийн технологийн төв ТӨҮГ, Эрүүл мэндийн хөгжлийн албатай хамтран Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан 25 мэргэжилтэнд "Үндэсний хэмжээний эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах нь" сэдэвт онол-дадлага хосолсон 2 өдрийн сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 31-нээс 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтаас гарсан зөвлөмжийг Бодлого, төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Тусгай зөвшөөрлийн комиссын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4/4501 албан бичгээр хүргүүлэв. | 2024.10.01-2024.11.01 | 100% |
| | Дэд арга хэмжээ 3.1.1<br>Гааль, Татвар, Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран аймаг, нийслэлийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг сургах сургалтын | Сургалтын хөтөлбөр, тайлан | Сургалт зохион байгуулагдсан байна. | Батлагдсан сургалтын хөтөлбөр<br><br>Сургалтын тайлан | Гааль, Татвар, Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран аймаг, нийслэлийн тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг сургах сургалтын хөтөлбөр боловсруулж, Тусгай зөвшөөрлийн комиссын даргын удирдамжаар батлуулан хэрэгжүүлж ажилласан. | | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр боловсруулж батлуулна. | | | | | | |
| | Дэд арга хэмжээ 3.1.2 Гааль, Татвар, Санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран тусгай зөвшөөрөл олгох байгууллагын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулна. | Сургалтын хөтөлбөр, тайлан | Сургалт зохион байгуулагдсан байна. | Батлагдсан сургалтын хөтөлбөр<br><br>Сургалтын тайлан | Авлигатай тэмцэх газар, Гааль, санхүүгийн мэдээллийн технологийн төв ТӨҮГ, Эрүүл мэндийн хөгжлийн албатай хамтран Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан 25 мэргэжилтэнд "Үндэсний хэмжээний эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах нь" сэдэвт онол-дадлага хосолсон 2 өдрийн сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 31-нээс 11 дүгээр сарын 1-ний өдрүүдэд зохион байгуулж, сургалтаас гарсан зөвлөмжийг Бодлого, төлөвлөлтийн газрын дарга бөгөөд Тусгай зөвшөөрлийн комиссын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 4/4501 албан бичгээр хүргүүлэв. | | - |
| 2 | Арга хэмжээ 3.2 "Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх" тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагад явцын хяналт-үнэлгээг үе шаттай хийнэ. | Явцын хяналт-үнэлгээний тайлан | | | - Тусгай зөвшөөрлийн комиссын даргаар 2 удаагийн удирдамж батлуулан 2023 оны 5-7-р сард эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан 21 эрүүл мэндийн байгууллагыг явцын хяналт үнэлгээнд хамруулсан.<br>- Явцын үнэлгээний тайланг Тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 2 болон 5 дугаар сарын 29-ний өдрийн 4 дүгээр хурлаар тус тус хэлэлцүүлсэн.<br>- Үнэлгээний дүнгээр ажлын байр өөрчлөгдсөн 2 байгууллагад хаягийн өөрчлөлт хийлгэх зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилласан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |



36

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Дэд арга хэмжээ 3.2.1 “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагад явцын хяналт-үнэлгээний удирдамж боловсруулж батлуулна. | Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдамж | | Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдамж гарсан байна. | - Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад явцын хяналт үнэлгээ хийх ажлын удирдамжийг 2 удаа боловсруулан батлуулж мөрдөж ажиллалаа. | | - |
| | Арга хэмжээ 3.2.2 “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагад явцын хяналт-үнэлгээг үе шаттай хийнэ. | Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тоо, тайлан | | Явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж гарсан байна. | - Тусгай зөвшөөрлийн комиссын даргаар 2 удаагийн удирдамж батлуулан 2023 оны 5-7-р сард эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан 21 эрүүл мэндийн байгууллагыг явцын хяналт үнэлгээнд хамруулсан.<br>- Явцын үнэлгээний тайланг Тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 2 болон 5 дугаар сарын 29-ний өдрийн 4 дүгээр хурлаар тус тус хэлэлцүүлсэн.<br>- Үнэлгээний дүнгээр ажлын байр өөрчлөгдсөн 2 байгууллагад хаягийн өөрчлөлт хийлгэх зөвлөмж өгч хэрэгжүүлэн ажилласан. | | - |
| 3 | Арга хэмжээ 3.3 Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагуудад | Явцын хяналт-үнэлгээний тайлан | | | Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс 2 удаагийн удирдамжаар 4 аймгийн 17, Улаанбаатар хотын 27 эрүүл мэндийн байгууллагад явцын хяналт-үнэлгээ хийж, үнэлгээний тайлан, зөвлөмжийг | 2024.01.01-2024.06.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | явцын хяналт-үнэлгээ хийнэ. | | | | албажуулан холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа. | | |
| Зорилт 4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1. | Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдөн ажиллана. | Ёс зүйн зөрчил гаргасан эсэх | Ёс зүйн зөрчил гаргахгүй ажиллах | Ёс зүйн зөрчилгүй ажилласан байна. | Ёс зүйн зөрчилгүй ажилласан болно. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2. | Сайд, дэд сайд, ТНБД, газрын даргаас өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэнэ. | Нэмэлтээр гүйцэтгэсэн үүрэг даалгаврын тоо | Хугацаанд нь чанартай гүйцэтгэнэ. | Нэмэлт үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. | Сайд, дэд сайд, ТНБД, газрын даргаас өгсөн үүрэг, даалгаврыг бүрэн биелүүлж ажилласан болно. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 3. | Албан бичиг, өргөдлийг журмын дагуу шийдвэрлэнэ. | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо | Хугацаанд нь шийдвэрлэнэ. | Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо | Тайлангийн хугацаанд нийт 593 албан бичгийг хүлээн авч шийдвэрлэн, 205 албан бичгийг илгээсэн байна. Иргэдээс нийт 63 өргөдөл гомдлыг хүлээн авч, шийдвэрлэж ажиллалаа. Магадлан итгэмжлэл, тусгай зөвшөөрөлтэй холбоотой баримт бичгийг цэгцэлж, архивын 84 нэгж бэлтгэн хүлээлгэн өгсөн. | 2024.01.01-2024.12.31 | 100% |

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт



64

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Эрүүл мэндийн ажилтны шагналын асуудлыг түр хариуцах | Төрийн дээд одон медальд нэр дэвшигчийг уламжилсан албан тоот | | Төрийн дээд одон медальд нэр дэвшигчийг уламжилсан албан тоот | Монгол Улсын төрийн дээд цол, одон медальд нэр дэвшүүлсэн эрүүл мэндийн ажилтны мэдээллийг бэлтгэн ЕТГ-т 3 удаа албан бичиг илгээсэн болно. | 2024.01.01-2024.06.31 | 100% |
| | | Эрүүл мэндийн салбарын шагнал олгосон удаа | | Эрүүл мэндийн салбарын шагнал олгосон удаа | Эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжээс ирүүлсэн албан хүсэлтийн дагуу шаардлага хангасан 1176 гаруй эрүүл мэндийн ажилтанд “Жуух бичиг”, 930 эрүүл мэндийн ажилтныг “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” тэмдгээр шагнасан. | 2024.01.01-2024.06.31 | |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. “Эмч танаараа бахархья” арга хэмжээ зохион байгуулах | Арга хэмжээний төлөвлөгөө | | Арга хэмжээний төлөвлөгөө | Олон улсын эмч нарын өдөрт зориулан “Эмч танаараа бахархья” арга хэмжээний нарийн бичгийн даргаар ажиллаж, улсын хэмжээний 2500 эмч, эрүүл мэндийн ажилтнууд оролцсон арга хэмжээг зохион байгуулсан. | 2024.03.15-2024.03.30 | 100% |
| 3 | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. “Эрүүл мэндийн салбарын 7 хоног” арга хэмжээний зохион байгуулалтад оролцох | Бэлтгэл ажлын төлөвлөгөө | | Бэлтгэл ажлын төлөвлөгөө | УИХ-ын гишүүн, Засгийн газрын гишүүн, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайханы санаачилгаар “Эрүүл мэндийн салбарын 7 хоног” арга хэмжээний хүрээнд “Нийгмийн эрүүл мэндийн бодлого тэргүүлэх чиглэл болох нь” удирдах ажилтны зөвлөгөөн, Эмч нарын 7-р их хурал, Багийн бага эмч нарын анхдугаар зөвлөгөөний зохион байгуулалтад оролцсон. | 2024.10.15 2024.10.25 | 100% |

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Япон Улсын Нагоягийн их сургуулийн Докторын хөтөлбөрт суралцана. | Сургалтад хамрагдсан байна. | | Сургалтад хамрагдсан байна. | Япон Улсын Нагоягийн их сургуулийн Докторын хөтөлбөрт 2024 оны 5-р сарын 23-ны өдрөөс 6-р сарын 6-ны өдрийг хүртэл, 11 дүгээр сарын 10-22-ны өдрүүдэд танхимын сургалтад хамрагдсан. | 2024.01.01-2024.12.31 | 100% |
| 2 | Арга хэмжээ 2. Ажлын байрны чиг үүргийн дагуу богино хугацааны сургалтад хамрагдана. | Сургалтад хамрагдсан байна. | | Сургалтад хамрагдсан байна. | ТАЗ-өөс цахим сургалтад 12 удаа хамрагдсан. | 2024.09.01-2024.12.15 | 100% |
| 3. | Арга хэмжээ 3. ТАЗ-өөс зохион байгуулдаг 7 хоног тутмын цахим сургалтад хамрагдана. | ТАЗ-өөс 7 хоног тутам зохион байгуулдаг цахим сургалтад хамрагдсан хувь | | ТАЗ-өөс 7 хоног тутам зохион байгуулдаг цахим сургалтад хамрагдсан байна. | ТАЗ-өөс 7 хоног тутам зохион байгуулдаг цахим сургалтад хамрагдсан байна. | 2024.09.01-2024.12.31 | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ТЗУГ-ын мэргэжилтэн ...................... / ........................... / 2024.12.05

(Албан тушаал) (Нэр, гарын үсэг) (Огноо)